



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 3/53

Хэрлэн сум

Албан хаагчдыг шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 3.1, 3.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутаг дахь төрийн албан хаагчдад зориулсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого” сэдэвт сургалтыг орон нутагтаяа амжилттай зохион байгуулж, аймгийн хэмжээнд 18 сум, 5 тосгон, 31 төрийн байгууллагын нийт 3734 төрийн албан хаагчдыг хамруулсан тул аймгийн Засаг даргын Тамгын газрын зарим албан хаагчдыг үндсэн цалингийн хувиар шагнасугай.

- 2.Шагнал олгох албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.
- 3.Шагналд зарцуулах зардлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас гаргахыг Няглан бодогч (Э.Ариунтунгалаг)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын  
2023 оны ..... дугаар сарын ..... -ны өдрийн  
..... дугаар тушаалын хавсралт

Шагнал олгох албан хаагчдын нэрс

№	Албан хаагчийн нэр	Албан тушаал	Үндсэн цалин	Үндсэн цалингийн хувь
1	Т.Бямбадулам	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Нутгийн захиргааны байгууллагын бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	924456	20
2	Г.Ариунчимэг	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Үйлдвэр, хөдөө аж ахуй, хүнс, худалдаан үйлчилгээний бодлого хариуцсан мэргэжилтэн	853375	10
3	Н.Эрдэнэсүх	Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалт эрхэлсэн офицер	1250000	20
4	Д.Мягмарбаатар	Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн	924456	20
5	С.Лхагвацэрэн	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн	853375	20
6	Г.Пүрэвбаатар	Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл, хүүхэд, залуучуудын бодлого хариуцсан мэргэжилтэн	853375	20
7	Ж.Цэнджав	Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	853375	20
8	Ш.Эрдэнэжаргал	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	853375	20
9	Б.Ундралжаргал	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	853375	20
10	Г.Уянга	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Нутгийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн	924456	20